

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 6 ДУГААР
САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит долоодугаар хуралдаан 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдөр төлөөлөгчдийн 79,4 хувийн ирцтэйгээр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

1. Архангай аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэх бэлтгэл ажлыг зохион байгуулах хороо байгуулах тухай
2. Зарим сумдын ойг тэмдэглэх тухай
3. “Сүм, хийд байгуулах зөвшөөрөл олгох, түүний үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг батлах тухай
4. Тогтоол цуцлах тухай
5. Тээврийн хэрэгсэл данснаас хасаж, худалдах тухай
6. Орон нутгийн өмчөөс 2022 онд хувьчлах үл хөдлөх хөрөнгийн жагсаалт батлах тухай
7. Аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай
8. Аймгийн 2022 оны төсвийн тодотголыг батлах тухай
9. Аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
10. Газар нутгийг аймгийн тусгай хэрэгцээнд авах тухай гэсэн арван асуудлыг хэлэлцлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2022 оны 6 дугаар сарын 27-ны өдөр аймгийн удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж 5 дугаар сард өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг танилцуулж, Архангай аймаг дахь Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар цаг үеийн ажил, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж төрийн байгууллагын удирдах ажилтнуудад холбогдох үүрэг даалгавар болон цаашид анхаарах ажлын чиглэлийг өгсөн.

Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл 2022 оны 6 дугаар сарын 08, 13, 15, 16-ны өдрүүдэд Архангай аймгийн төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаал, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулж нийт 115 сул орон тооны сонгон шалгаруулалт зарласнаас 49 сул орон тоог нөхсөн байна.

Архангай аймгийн Засаг даргын тамгын газар нь 2021 оны 9 дүгээр сараас эхлэн Чанарын менежментийн тогтолцоо буюу ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж, хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс анхдагч баталгаажуулалтын хоёр дахь шатны аудитаар ямар нэгэн үл тохирол байхгүй, чанарын менежментийн тогтолцоог үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлсэн гэсэн үнэлгээ авч, 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр ISO 9001:2016 стандартын гэрчилгээгээ гардаж авлаа.

Хөдөө аж ахуйн салбарын тооллогыг Архангай аймагт 2022 оны 6 дугаар сарын 4-ний өдрөөс 17-ны өдрийн хооронд зохион байгуулж, мэдээлэл цуглуулалтын ажил 100 хувь хийгдэж дууссан, мэдээлэл боловсруулалтын ажил хийгдэж байна.

Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тогтоол, 2021 оны 278 дугаар тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогыг зохион байгуулах аймгийн комисс томилогдож, 2022 оны 3 дугаар улиралд үзлэг тооллогын ажлыг дуусгаж, дүнг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэхээр 19 сумын 171 орон нутгийн өмчит байгууллагад үзлэг тооллогын ажлыг явуулж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Цахим Архангай” төрийн шуурхай үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу “Цахим аймаг” хөтөлбөрийн төслийг

боловсруулж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн, 2022 оны 6 дугаар сард гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж Эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний цахим шийдэл, Сургуулийн сургалтын удирдлагын цахим шийдэл, Хөрөнгө оруулалтын удирдлагын цахим шийдэл, Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын цахим шийдэл, Аймгийн орон зайн мэдээллийн систем, Тээврийн хэрэгслийн хяналтын цахим шийдэл, Автомат шалган нэвтрүүлэх шийдэл, Аймгийн иргэдэд зориулсан нэгдсэн гар утасны аппликейшн зэрэг системүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Мөн орон нутгаас олгож байгаа тусгай зөвшөөрөл, архивын лавлагаа зэрэг төрийн үйлчилгээг И Монголиа нэгдсэн системд холбож хариуцсан мэргэжилтнүүд, сумдын оператор ажилтнуудын тоон гарын үсгийн мэдээллийг шинэчилж, сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн бөгөөд орон нутгийн оператор ажилтнуудаар дамжуулан улсын хэмжээнд 210 гаруй төрийн үйлчилгээг цахимаар үзүүлж, нийт ХУР, ДАН системээр иргэдэд 61 байгууллагын 660 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж байна.

Архангай аймгийн нутгийн захиргааны 13 байгууллагын 51 үйлчилгээ цахимжиж, "e-mongolia" системд нэвтэрлээ.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Төсвийн орлого, татвар төлөлт

2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар улсын төсвийн орлогод өссөн дүнгээр 1,315,317,352.2 төгрөг төвлөрүүлэхээс 1,342,534,841.7 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 102.1 хувь, аймгийн төсвийн орлогод өссөн дүнгээр 1,119,246,300.0 төгрөг төвлөрүүлэхээс 1,330,281,528.5 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 118.9 хувь, сумын төсвийн орлогод өссөн дүнгээр 6816195.9 төгрөг төвлөрүүлэхээс 6272242.2 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 92.0 хувийн тус тус биелэлттэй байна.

Хөрөнгө оруулалт

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 87922.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан бөгөөд 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 116033.6 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн. Төсвийн тодотголоор 700.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ хасагдсан. 400.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээний тендерийг 2 удаа зарласан боловч шаардлага хангасан тендер ирээгүй тул гэрээ шууд байгуулахаар хэлцэл зохион байгуулж байна. 39459.3 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний дахин тендерийг зарлаж, 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдөр нээсэн. Үнэлгээ хийгдэж байна. Үлдэх 75474.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 төсөл арга хэмжээний гэрээг байгуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 200.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн. Тендерийг 2 дахь удаа зарласан боловч Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тухайн тендер шалгаруулалтыг зогсоосон. Шийдвэр гараагүй.

Санхүүгийн хяналт

Санхүүгийн аудит хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан Булган сумын төсөвт албан газрууд, тус сумын Орон нутгийг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сангийн 2020-2021оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж, дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэсэн. Аудит, хяналт шалгалтаар 10.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийг улсын байцаагчийн актаар аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тогтоож, ажил сайжруулах мэргэжил арга зүйн зөвлөмж чиглэл өглөө.

**Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд
Хууль, хяналт**

Аймгийн хэмжээнд 2022 оны 6 дугаар сард 11 удаагийн аюулт үзэгдэл осол тохиолдсоны дотор объектын гал түймэр 6, эрэн хайх аврах ажиллагааны дуудлага 1, үерийн дуудлага 1, усанд осолдсон 1, хүний гоц халдварт өвчин /ковид-19/ цар тахал 2 тус тус гарч ОБГ-ын алба хаагчид дээрх гамшиг ослоос 10 иргэний амь нас, 85.2 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

2022 оны 6 дугаар сарын 08-ны өдөр Батцэнгэл суманд Гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулж, сургуульд сумын онцгой комисс, штаб, мэргэжлийн анги, ард иргэд нийт 130 гаруй хүний бүрэлдэхүүн оролцож, дадлага сургуулиар сумын онцгой комисс, штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, төрийн албан хаагчид, ард иргэдэд 9 цагийн танхимын, 32 цагийн дадлагын сургалт, Штабын бүрэлдэхүүнийг аранзны үзлэг, жагсаалын бэлтгэл, цагийн байдалд ажиллуулж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах дадлагыг эзэмшсэн байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 6 сарын байдлаар нийт 1381 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 499, зөрчлийн шинжтэй 882 гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 321 буюу 23.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 оны эхний 06 сарын байдлаар аймгийн хэмжээнд 238 холбогдогчтой 716.3 сая төгрөгийн хохиролтой 250 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хэрэг 73 буюу 29.2 хувь, холбогдогч нь 99 буюу 41.6 хувиар өссөн байна. Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 66 буюу 26.4 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 91 буюу 36.4 хувийг хулгайлах төрлийн гэмт хэрэг, 37 буюу 14.8 хувийг хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, 13 буюу 5.2 хувь нь авто ослын гэмт хэрэг, 19 буюу 43.6 хувь залилах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургууль, СӨБ-ын хоол үйлдвэрлэл, орчны аюулгүй байдал, хүнсний худалдаа, хүнсний зах, бөөний төв, хүнсний дэлгүүрүүдийн үйл ажиллагаанд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Прокурорын газар хамтран 9 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй 3 ажлын хэсэг шалгалт хийж, мэргэжил арга зүйн заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

Шалгалтад хамрагдсан 24 хүнсний дэлгүүрээс хадгалалтын хугацаа дууссан, чанар аюулгүй байдлаа алдсан, хаяг шошгын зөрчилтэй 85 нэр төрлийн 812 ширхэг 1886.0 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг тухайн аж ахуйн нэгжийн дотоодын хяналтаар устгуулж, 86 нэр төрлийн 2487.3 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг буцаан таталт хийлгүүлэхээр битүүмжиллээ.

Улсын бүртгэлийн үйлчилгээ

2022 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар дараах бүртгэлийн хийж гүйцэтгэсэн байна.

Төрсний бүртгэл – 116

Овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 9

Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 8

Гэрлэсний бүртгэл - 22

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл- 5

Үрчилсний бүртгэл - 6

Нас барсны бүртгэл - 40

Шинээр иргэний үнэмлэх олгосон - 99

Дахин олгосон – 16

Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 157 бүртгэл хийгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл –40

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 18

Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл –2

Худалдах худалдан авах гэрээ – 90

Бэлэглэлийн гэрээ – 8

Барьцааны эрхийн бүртгэл – 231

Өв залгамжлал – 9
Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 9
Лавлагаа – 5
Бусад эрхийн бүртгэл – 18

Хууль хяналтын байгууллагад нийт 35 лавлагааг гарган хүргүүлсэн. Дээрхи бүртгэлүүдийг хийж үйлчилгээний хөлс 3403274 төгрөг, тэмдэгтийн хураамжид 278103 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 18787840 төгрөгийг тус тус улсыг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Шинээр бүртгүүлсэн – 29
Өөрчлөлт – 122
Тамганы хяналтын дугаар олгосон –34 бүртгэл хийсэн.

Шүүхийн шинжилгээний алба 2022 оны 6 дугаар сард криминалистикийн шинжилгээ 2, шүүх эмнэлгийн шинжилгээ 33, 20 тусгай шинжилгээ хийж холбогдох дүгнэлтийг гаргасан.

2022 оны Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2495296.1 төгрөгийн мөнгөн дүн бүхий 369 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 43, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 22.7 байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсрол

Архангай аймагт элсэлтийн ерөнхий шалгалт 2022 оны 6 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд Эрдэнэбулган сумын Лаборатори 1-р сургууль дээр зохион байгууллаа. Элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр аймгийн хэмжээнд 989 шалгуулагч 2686 шалгалт өгөхөөр бүртгүүлснээс нийт 2466 шалгалтыг бүрэн өгч 92 хувийн ирцтэйгээр элсэлтийн ерөнхий шалгалтад оролцсон байна.

Математикийн хичээлээр 2, Монгол хэлний хичээлээр 1 хүүхэд тус тус 800 оноо авсан байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын улсын дундаж 500.0 оноо байдаг бөгөөд Архангай аймгийн хувьд элсэлтийн ерөнхий шалгалтын 10 хичээлээс 3 хичээл /орос хэл, англи хэл, хими/ улсын дунджаас доогуур, бусад хичээлийн хувьд улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэйгээр ЭЕШ-ын дундаж оноо гарсан байна.

Шалгуулагчид нийт 2466 шалгалт өгснөөс 1100 шалгалт буюу нийт шалгалтын 44.6 хувийг улсын дунджаас дээгүүр буюу 500.0-аас дээш оноотойгоор шалгуулсан байна.

Эрүүл мэнд

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал

Батлагдсан тохиолдол:

Нийт батлагдсан тохиолдол /2021-2022 он/- 17220

Үүнээс: 2022 онд – 4357

Сүүлийн 7 хоногт батлагдсан тохиолдол – 2

Нас баралт:

Нийт нас баралт – 42

Үүнээс: 2021 онд – 39

2022 онд - 3

Түргэвчилсэн шинжилгээ:

Нийт хийсэн түргэвчилсэн шинжилгээ /2021-2022 он/ - 51284

Үүнээс 2022 онд: - 8127

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 18

Үүнээс эерэг – 0

ПСР шинжилгээ:

Нийт хийсэн ПСР шинжилгээ /2021-2022 он/ - 88466

Үүнээс 2022 онд - 10954

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 97

Үүнээс эерэг – 3

Вакцинжуулалт:

1-р тунд 60777 хүн буюу 86,2 % /12-оос дээш нас/

2-р тунд 57564 хүн буюу 81,8 % /12-оос дээш нас/

3-р тунд 27192 хүн буюу 50,2 % /18-аас дээш нас/

4-р тунд 2380 хүн буюу 4,5 % /18-аас дээш нас/

Биеийн тамир, спорт

Узбекистан улсын Ташкент хотно 2022 оны 6 дугаар сарын зохиогдсон 100 буудалт даамны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1-р сургуулийн сурагч Э.Эрхэмбаяр алтан медаль, Хайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагч Хүслэнзаяа 2 алт, 1 мөнгөн медаль авч Ази тивийн аварга болсон байна.

Монгол Улсын Засгийн газрын Олимпизмыг дэлгэрүүлэх, хүний хөгжлийн шалгуур үзүүлэлтийг хангах, амьдралын чанарыг дээшлүүлэх Үндэсний хорооны үйл ажиллагааны хүрээнд “Олимпын боловсрол ба бие бялдарын хүмүүжил” сэдэвт Болзолт уралдаан нийт ерөнхий боловсролын сургуулиудын дунд таван сарын турш амжилттай өрнөж, шилдгээр шалгарсан хүмүүс шагналаа гардаж авлаа.

Энэ удаагийн болзолт уралдаанд 21 аймаг, 9 дүүргийн 400 гаруй ерөнхий боловсролын сургууль оролцож, 1300 гаруй удаагийн арга хэмжээнд сурагч, багш, эцэг эхчүүд зэрэг нийт 400,000 гаруй хүн хамрагдсан байна.

Болзолт уралдаанд аймаг, дүүрэг тус бүрээс шалгарсан шилдэг 30 багш, арга зүйч болон таван Олимпын зөвлөлийн төлөөллийг гадаадад туршлага судлах эрхийн бичгээр, шилдэг 30 сургууль, таван Боловсролын газар, таван Биеийн тамир, спортын газар болон таван Олимпын танхимыг тус тус үнэ бүхий зүйлсээр шагнаж урамшуулахад “Олимпын боловсрол ба бие бялдарын хүмүүжил” сэдэвт “Шилдэг олимпын зөвлөл” болзолт уралдаанд Архангай аймгийн Мехико олимпын зөвлөл тавдугаар байр, “Шилдэг Боловсрол, шинжлэх ухааны газар” болзолт уралдаанд Архангай аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нэгдүгээр байр, “Шилдэг сургууль” болзолт уралдаанд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын спортын төрөлжсөн сургалттай 5 дугаар сургууль тэргүүн байр, “Шилдэг багш” болзолт уралдаанд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 5 дугаар цэцэрлэгийн багш Н.Чимэдмаа тэргүүн байр эзэлж амжилттай оролцлоо.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2022 оны 6 дугаар сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 966 иргэн бүртгэлтэй байгаагаас 480 эмэгтэй. Шинэ ажлын байр 117, үүнээс байнгын ажлын байр 102 байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд нийт 2.4 сая толгой хээлтэгч мал тоологдсоноос төллөвөл зохих 2.1 сая толгой хээлтэгч малын 95.1 хувь буюу 2.0 сая толгой хээлтэгч мал төллөж 1.9 сая толгой төл мал 96.7 хувьтай бойжиж байна. Үүнээс төллөсөн хээлтэгч ингэ 275 буюу 96.1%, гүү 100965 буюу 89.8%, үнээ 203015 буюу 88.8%, эм хонь 1160497 буюу 97.6% эм ямаа 543464 буюу 93.6 хувь нь, нийт бог малын хээлтэгчийн 96.3 хувь, бод малын хээлтэгчийн 89.1 хувь нь төллөсөн байна.

Аймгийн хэмжээнд 5.5 сая толгой мал тоологдсоноос нийт мал сүргийн 0.5 хувь буюу 30174 толгой мал хорогдсон.

2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр Эрдэнэмандал суманд тус сумын 6 багийн 240 орчим малчдыг оролцуулсан малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж бэлчээрийн даац, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, эрчимжсэн мал аж ахуй, малчдын амьдралын чанарын талаар 1 өдрийн мэдээлэл авч хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Тариалалт

Архангай аймаг 2022 онд аймгийн хэмжээнд 8265 га-д үр тариа, үүнээс 7965 га-д улаанбуудай, 4100 га-д малын тэжээл, 600 га-д тосны ургамал, 275 га-д төмс, 166 га-д хүнсний ногоо, 80 га-д жимс жимсгэнэ, нийтдээ 13486 га-д тариалалт хийж 7600 га-д уринш боловсруулахаар төлөвлөснөөс 2022 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар улаанбуудай 10403 га-д тариалж 130%, арвай 70 га-д тариалж 70%, хошуу будаа 340 га-д тариалж 170%, тосны ургамал 995 га-д тариалж 166%, малын тэжээл 1423 га-д тариалж 35%, хүнсний ногоо 130,6 га-д тариалж 79%, төмс 232 га-д тариалж 85%, жимс, жимсгэнэ 84 га-д тариалж 105%, нийт тариалалт 101% хувьтай байна.

Хаврын тариалалтад трактор 346, үр тариа үрлэгч 31, хүнсний ногооны үрлэгч 7, анжис 26, борной 39, бул 11, өргөн холбоо 10, сэндэчлүүр 7, бүх төрлийн сийрүүлэгч 13, хор цацагч 8, бордоо, бууц цацагч 3, 1-25 га-г услах хүчин чадал бүхий услах бороожуулагч 3, төмс, хүнсний ногооны бага оврын иж бүрдэл трактор 3, нийт 507 техник хэрэгсэл ажиллаж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд Байгаль орчин

Ногоон байгууламж, мод тарих

Архангай аймаг нь Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2030 оныг хүртэлх хугацаанд 20 сая мод тарьж ургуулах төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/713 дугаар захирамжаар байгуулан аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 19 сумын хэмжээнд 247716 ширхэг мод, бут сөөгийг үрээр болон тарьц суулгацаар тарьж усалгаа, арчилгааны ажлыг гүйцэтгэж байна. Энэ жилийн мод тарих ажлаар төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор сумдын төвийн хашаа, хамгаалалттай сад, цэцэрлэгт хүрээлэнг засаж сэлбэж сайжруулан мод тарих чиглэлийг Засаг дарга нар өгч хамтран ажиллаж байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, элсний нүүлтийг зогсоох, иргэдийн ажиллаж амьдарч буй орчныг ногоон байгууламжтай болгох зорилгоор нэг иргэн нэг мод уриалгыг өрнүүлж иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Мөн Ойн тухай хуулийн 30 дугаар 30.2 дугаар зүйлд заасны дагуу Ойн мэргэжлийн байгууллагууд бэлтгэсэн модныхоо тоо хэмжээнээс хамааруулан ойжуулалтын ажлыг өөрсдийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байна.

2022 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт 468.0 мянган ширхэг модыг тарихаар төлөвлөснөөс ажлын гүйцэтгэл 52.9 хувьтай байна.

4 дэх жилдээ амжилттай хэрэгжиж байгаа “Чулуут тул 2030” төслийн хүрээнд 2022 онд 580 мянган зэвэг, хадрангийн түрс бойжуулж, 170 мянга, төсөл хэрэгжсэн дөрвөн жилийн хугацаанд Чулуут голд нийт 1.730.000 зэвэг, хадрангийн жараахайг тавьсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мод үржүүлгийн газарт 4000 ширхэг улиас, бургасны мөчрийг ил талбайд хөрс боловсруулалтыг ажлыг хийж, технологийн дагуу тарьж усалгааны ажил, үрийн хэсэг буюу 20*6, 10*6 хэмжээтэй 2 хүлэмжийн үржил шимгүй болсон хуучин хөрсийг сольж, хар шороо, элс, хөх бууцны нөөцийг бүрдүүлж, шинээр 50 гаруй м³ хиймэл хөрс боловсруулж 5 кг шинэс, 3 кг хайлаасны үрийг тарьж, усалгаа арчилгааг тус тус гүйцэтгэж байна.

Эрдэнэбулган сумын нийтийн эзэмшлийн талбайд ургаж буй мод, сөөгний нарийвчилсан судалгааг гаргаж 34 цэцэрлэгт хүрээлэнд шинэс, улиас, гацуур, нарс, хайлаас, бургас, шар хуайс, агч, гүйлс, хуш, голт бор зэрэг нийт 11 нэр төрлийн 26414 мод, сөөг ургаж байна. Насжилтын хувьд хамгийн бага нь 5 настай, дээд тал нь 5-85 жилийн настай мод 48 га талбайд ургаж байна.

Ойн сангийн хортон шавьжтай тэмцэх ажил

Архангай аймагт ойн сан бүхий 15 сумын 29015 га талбайд ойн хортон шавжтай тэмцэх ажлыг зайлшгүй явуулах шаардлагатай гэсэн 2021 онд судалгаа хийснээс 2022 онд 15 сумын 13165 га талбайд ойн хортон шавьжтай тэмцэх ажилд шаардагдах 321 сая төгрөгийн зардлыг 2021, 2022 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал, байгалийн нөөц ашигласны төлбөрийн давсан орлого, орон нутгийн хөгжлийн сан, малын тоо толгойд татвар ногдуулсанаас олсон орлого зэрэг эх үүсвэрээс шийдвэрлэж, тэмцлийн ажлыг гүйцэтгүүлж эхлээд байна.

Тариат суманд 2830 га-д төлөвлөснөөс 1500 га-д, Өндөр-Улаан суманд 1780 га-гаас 1000 га-д, Чулуут суманд 1930 га-гаас 800 га-д, Цэцэрлэг суманд 500 га-гаас 1330 га-д, Цэнхэр суманд 3900 га-гаас 2000 га-д, Төвшрүүлэх суманд 2830 га-гаас 1500 га-д, Жаргалант суманд 1780 га-гаас 1000 га-д, Эрдэнэмандал суманд 1610 га-гаас 250 га-д, Хайрхан суманд 750 га-гаас 750 га-д, нийт 10130 га-д хортон шавжтай тэмцэх ажлыг гүйцэтгэж, аймгийн хэмжээнд тэмцлийн ажлын гүйцэтгэл 76.9 хувьтай байна.

Барилга, дэд бүтэц, газар

2022 оны 6 дугаар сард орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 12 барилгын барилга угсралтын ажлын явцад захиалагчийн хяналтыг хийж гүйцэтгэсэн.

Орон сууц, барилга байгууламж

2022 онд “Гост трейд” ХХК-ийн “Хангайн төгөл” эвент халл ресторан, иргэн Чилхаасүмбэрэлийн 3 давхар зочид буудал, рестораны барилга тус тус ашиглалтад орсон байна.

2022 аймгийн хэмжээнд дараах 10 орон сууц баригдаж байна. Үүнд:

1. “Гурван тамир” ХХК - Орон сууцны барилга - 5 давхар 15 айл - гүйцэтгэл 40 хувь.
2. “Мөнх өсөх өргөө” ХХК - Үйлчилгээ, орон сууцны цогцолбор барилга - 5 давхар 4 блок 120 айл - гүйцэтгэл 40 хувь.
3. Иргэн Н.Манлай - Үйлчилгээтэй орон сууцны цогцолбор хотхон - 6 давхар 4 блок 192 айл - гүйцэтгэл А блок - 80%, Б блок - 20%
4. Иргэн Б.Бямбаа - Үйлчилгээтэй орон сууцны барилга - 6 давхар 60 айл - гүйцэтгэл 80 хувь
5. “Цагаан сүмбэр” ХХК - орон сууц - 5 давхар 50 айл - гүйцэтгэл 70 хувь.
6. Иргэн Сүхбаатар - орон сууц - 4 давхар 12 айл - гүйцэтгэл 90 хувь.
7. Иргэн Б.Бямбаа - орон сууц - 5 давхар 4 блок - гүйцэтгэл А блок - 10 хувь.
8. Иргэн Чулуунбаатар – Үйлчилгээтэй орон сууц - 5 давхар 18 айл - гүйцэтгэл 40 хувь.
9. “Сайхан тэрх” ХХК – Үйлчилгээтэй орон сууц - 5 давхар 23 айл - гүйцэтгэл 70 хувь.
10. Иргэн Бадралт - орон сууц - 6 давхар 30 айл - гүйцэтгэл 70 хувь.

Хүнс

Дотоодын үйлдвэрлэлээр мах, махан бүтээгдэхүүн 4.1 мян.тн бэлтгэж 100%, сүү, сүүн бүтээгдэхүүн 0.3 мян.тн бэлтгэж 12.5%, гурил 0.03 мян.тн бэлтгэж 4%, гурилан бүтээгдэхүүн 0.4 мян.тн бэлтгэж 33%, өндөг 0.012 бэлтгэж 8.6 хувиар аймгийн хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг хангасан байна. Зориулалтын агуулахад 6 иргэн 230 тн мах нөөцөлсөн байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ

Худалдаа, үйлдвэр үйлчилгээний “ГОСТ трейд” ХХК аймаг орон нутгийн хөгжилд өнгө үзэмж нэмсэн, улсын жишигт нийцсэн “Хангайн төгөл” эвент холл ресторан, UNI кофе шофыг нээж, үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

“Хөдөө аж ахуйг дэмжих дэмжих зээл”-ийн 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар Хаан банканд 2 иргэн, аж ахуйн нэгжид 90,0 сая төгрөгийн зээл олгож, Төрийн банк, Хас банк, Голомт банк 18 иргэн, аж ахуйн нэгжийн зээл судлагдаж байна.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд “Хаан” банк, “Төрийн” банкаар дамжуулан Иргэдэд зориулсан хөрөнгө оруулалт, эргэлтийн

хөрөнгийн зээл жилийн 10,8 хувийн хүүтэй, Бизнес эрхлэгчдэд зориулан хөрөнгө оруулалтын зээл жилийн 12 хувийн хүүтэй зээлийг олгож байна. Энэхүү зээлийн хүрээнд аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар 11 аж ахуйн нэгжид 752,5 сая төгрөг, 66 иргэнд 752,4 сая төгрөг нийт 1 тэрбум 504,9 сая төгрөгийн зээл олгоод байна. Үүнээс 27 зээлдэгч 326,3 сая төгрөгийн төслийн батлан даалтад хамрагдсан байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----